

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗАГВАР ГЭРЭЭ**

“_____” **ХХК** /захиалагчийн нэрийг оруулна уу/,

-болон-

“_____” **ХХК** /ажил гүйцэтгэгчийн нэрийг оруулна уу/

нарын хооронд байгуулсан

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

(ЗАГВАР)

20__ он

Улаанбаатар хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

20__ оны __ дугаар/дүгээр
сарын __-ны/ний өдөр

Улаанбаатар хот

Энэхүү ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (энэхүү гэрээнд оруулах аливаа нэмэлт өөрчлөлт болон хавсаргах хавсралтын хамт)-г

нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, _____ дүүрэг, _____ хороо, _____ байр, _____ давхар _____ тоот хаягт бүртгэлтэй, улсын бүртгэлийн дугаар: _____, регистрын дугаар _____ бүхий Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болох _____ ХХК (*Захиалагчийн нэрийг оруулна уу*) (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж захирал _____ (*Захирлын нэрийг оруулна уу*), болон

нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, _____ дүүрэг, _____ хороо, _____ байр, _____ давхар _____ тоот хаягт бүртгэлтэй, улсын бүртгэлийн дугаар: _____, регистрын дугаар _____ бүхий Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болох _____ ХХК (*Ажил гүйцэтгэгчийн нэрийг оруулна уу*) (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж захирал _____ (*Захирлын нэрийг оруулна уу*) (цаашид тусад нь “Тал” хамтад нь “Талууд” гэх”) нар

20__ оны __-р сарын __-ны/ний өдөр дараах нөхцөл, журмын дагуу байгуулав.

УДИРТГАЛ

Захиалагч нь Монгол Улс, Улаанбаатар хот, _____ дүүрэг, _____ хороо, _____ байр, _____ давхар _____ тоот хаягт байрлах барилга байгууламжийн өмчлөгч/эзэмшигч бөгөөд тухайн барилга байгууламжийн эрчим хүчний зарцуулалт болон түүний холбогдох зардлыг багасгах зорилгоор, тус барилга байгууламжийн ашиглаж буй эрчим хүчийг хэмнэх, түүнийг үр ашигтай хэрэглэхтэй холбогдуулан эрчим хүчний хэмнэлт гаргадаг тоног төхөөрөмжийг худалдан авах, суурилуулах, ажиллуулах, ашиглалтанд байлгах, эрчим хүчний хэмнэлтийг тооцоолуулах, баталгаажуулах болон эдгээртэй холбоотой бусад ажил, үйлчилгээг авахаар Ажил гүйцэтгэгчтэй энэхүү Гэрээг байгуулж байгаа болно.

Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн хүсэлтээр түүний өмчлөл/эзэмшлийн барилга байгууламжид эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх зорилготой

эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн, энэ чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин, тоног төхөөрөмжтэй тул энэхүү гэрээг байгуулж байгаа болно. Энэхүү Гэрээий ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ-тэй

холбогдуулан баримтлах бүхий л нөхцөл, журмыг тогтоох зорилгоор Талууд дор дурдсанаар харилцан тохиролцсон болно.

ИЙМД ДЭЭР ДУРДСАН УДИРТГАЛ ХЭСГИЙГ ҮНДЭСЛЭЛ БОЛГОН энэхүү Гэрээнд заасан хамтын баталгаа, батламж, харилцан тохиролцоо болон зөвшилцлийг харгалзан үзэж Талууд дараах зүйлсийг үүгээр хүлээн зөвшөөрч, баталж, зөвшөөрч байна.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээг Иргэний хуулийн нийтлэг үндэслэл, ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалт болон Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг удирдлага болгохын зэрэгцээ хэрэв ажил гүйцэтгэгч нь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдтэй энэхүү гэрээг байгуулах бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно.

1.2. Захиалагч нь өөрийн объектод эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг Ажил гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэнээр тухайн объектын эрчим хүчний хэрэглээний зардлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх зорилготойгоор энэхүү гэрээг байгуулж байгаа болно.

1.3. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн объектод эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээ гүйцэтгэснээр эрчим хүчний хэмнэлтийн үр ашгаас өөрт ногдох хувийг хуваарилан өөрийн хөрөнгө оруулалтыг нөхөж, ашиг олох зорилготойгоор энэхүү гэрээг байгуулна.

1.4. Энэхүү гэрээнд эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хэмжүүрийн нэгж нь кВт.цаг энерги байна.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

2.1. Нэр томьёоны тодорхойлолт

Энэхүү гэрээнд тодорхойлсон нэр томьёог дор дурдсан шууд утгаар ойлгоно. Мөн дурдаагүй бусад нэр томьёог талууд харилцан тохиролцон тусгаж болох ба хууль тогтоомжид тодорхойлсон утгаар ойлгож болно. Үүнд:

2.1.1. **“Захиалагч”** гэж өөрийн барилга байгууламжид эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ хүлээн авахаар энэхүү гэрээг байгуулж байгаа Монгол Улс, Улаанбаатар хот, _____ дүүрэг, _____ хороо, _____ байр, _____ давхар _____ тоот хаягт бүртгэлтэй, улсын бүртгэлийн дугаар: _____, регистрийн дугаар _____ бүхий Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болох _____ ХХК-ийг;

2.1.2. **“Ажил гүйцэтгэгч”** гэж Захиалагчид эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх ажил гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий Эрчим хүчний үр ашгийн

үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага гэж магадлан итгэмжлэгдсэн, мэргэшсэн эрчим хүч хэмнэлтийн менежер буюу ажилтантай, Монгол Улс, Улаанбаатар хот, _____ дүүрэг, _____ хороо, _____ байр, _____ давхар _____ тоот хаягт бүртгэлтэй, улсын бүртгэлийн дугаар: _____, регистрийн дугаар _____ бүхий Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болох _____ ХХК-ийг;

2.1.3. **“Эрчим хүч хэмнэлт”** гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний эхний болон дараах эрчим хүчний хэрэглээнд хэмжилт буюу тооцоогоор гарсан зөрүүг;

2.1.4. **“Эрчим хүчний үр ашиг”** гэж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашигтай хэрэглэсэн эрчим хүчийг нийт зарцуулсан эрчим хүчинд харьцуулсан харьцааг;

2.1.5. **“Эрчим хүчний хэмнэлтийн ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх”** гэж эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой энэхүү гэрээгээр тохиролцсон ажил гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэхийг;

2.1.6. **“Захиалагчийн объект”** гэж Захиалагчийн өмчлөл/эзэмшлийн Монгол Улс, Улаанбаатар хот, _____ дүүрэг, _____ хороо, _____ байр, _____ давхар _____ тоот хаягт _____ зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг;

2.1.7. **“Эрчим хүчний аудитын байгууллага”** гэж захиалагчийн эрчим хүчний хэрэглээнд шинжилгээ хийж үр ашгийг тооцох, дүгнэлт гаргах, эрчим хүч хэмнэх зөвлөмж өгөх хараат бусаар эрчим хүчний аудитын үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийг;

2.1.8. **“Тоног төхөөрөмж”** гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд ашиглаж байгаа эрчим хүчний хэмнэлтийн болон хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгслийг.

2.2. Тайлбар

Гарчгийг зөвхөн энэхүү Гэрээг хэрэглэхэд дөхөм болгох үүднээс өгсөн бөгөөд тайлбарт нөлөө үзүүлэхгүй байна. Тухайн агуулга нь өөрөөр илэрхийлж байгаагаас бусад тохиолдолд дараах дүрэм мөрдөгдөнө:

- а. Нэг тоогоор олон тоог төлөөлүүлж болох ба олон тоогоор нэг тоог төлөөлүүлэн хэрэглэж болно.
- б. Үг, хэллэгийг тодорхойлсон бол түүний дүрмийн бусад хэлбэрийг өмнөх утгатай холбогдуулан ойлгоно.
- в. Өөрөөр заагаагүй бол “зүйл”, “заалт”, “мөр”, “удиртгал” нь энэхүү Гэрээнд заасан зүйл, заалт, мөр, удиртгалыг илэрхийлнэ.
- г. Гэрээ эсвэл баримт бичиг гэдэгт энэхүү Гэрээ эсвэл аливаа бусад гэрээ буюу баримт бичгээр хориглосноос бусад тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулсан, өөрчилсөн, орлуулсан нь тухайн гэрээ, баримт бичгийг илэрхийлнэ.

д. Энэхүү Гэрээ, өөр гэрээ эсвэл баримт бичигт Тал гэж заасан бол түүний залгамжлагч, зөвшөөрөгдсөн орлох этгээд, эрх үүргийг шилжүүлэн авагч (хэрэв хамаарах бол тухайн Талын хууль ёсны төлөөлөгч) орно.

е. Хууль тогтоомж эсвэл хууль тогтоомжийн заалт гэдэгт түүний өөрчлөлт, нэмэлт, шинэчлэн найруулалт, орлуулсан хууль тогтоомжийн заалт, түүний дагуу гаргасан журам, хууль зүйн баримт бичиг орно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

3.1. Ажил гүйцэтгэгч нь _____ [өөрийн эсвэл захиалагчийн материал, тоног төхөөрөмж]-р _____ [Ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил тус бүрийг энэ хэсэгт оруулах, ямар ямар ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлэхийг] эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг (цаашид “Ажил” гэх) хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ.

3.2. Ажил гүйцэтгэх газар нь _____ [Захиалагчийн объект оршин байх газар буюу эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх газар] хаягт оршин байна.

3.3. Ажил гүйцэтгэгч Эрчим хүчний хэмнэлтийн ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулан _____ [гэрээний баталгаат хугацаа дуусахад эсвэл тоног төхөөрөмжийн өмчлөх эрх шилжүүлэх тусгай нөхцөл] Захиалагчийн өмчлөлд шилжүүлнэ.

3.4. Захиалагч Ажлыг ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээн авснаар гэрээний үнэ _____ төгрөгийг төлбөр төлөх хуваарийн дагуу төлнө.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ГЭРЭЭНИЙ ҮНЭ

4.1. Гэрээний үнэ _____ төгрөг [мөнгөн дүн] байна.

4.2. Гүйцэтгэх Ажлын үнийн дүнгийн задаргааг хавсралт 2 дахь Ажлын төсөвт тусгана.

4.3. Эрчим хүчний хэмнэлтийг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд тухайн эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох цаг хугацаанд Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифын үнийг баримтална.

4.4. Энэ зүйлд заасан тарифын үнэ нь Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт тул түүнд өөрчлөлт орох бүрт тухайн тарифын үнийг дагаж мөрдсөн хугацаанд тус гэрээний үнийг нэгэн адил дагаж мөрдөнө.

ТАВДУГААР ЗҮЙЛ ГЭРЭЭНИЙ ОБЪЕКТ

5.1. Ажил гүйцэтгэгч нь _____ объектод
[хавсралт 3-д заасан Ажил гүйцэтгэх Захиалагчийн объектууд] Ажлыг гүйцэтгэнэ.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн объектод дараах Ажлыг зохих ёсоор, шударгаар, хугацаанд нь гүйцэтгэнэ:

6.1.1. Гүйцэтгэх хуудсанд заасан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу Ажлыг гүйцэтгэнэ.

6.1.2. Гүйцэтгэх хуудсанд заасан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу Ажлыг хэрэгжүүлэх үе шат, түүний онцлог шинжүүдийг тусгасан ажлын төлөвлөгөөг боловсруулна.

6.1.3. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүхий л зардлыг хариуцна. *[Талууд харилцан тохиролцсоны дагуу эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнд хамаарах зардлыг захиалагч эсвэл ажил гүйцэтгэгч хариуцна]*

6.1.4. _____ *[тоног төхөөрөмжид тавигдах шаардлага]* шаардлагыг хангасан тоног төхөөрөмжийг Захиалагчийн объектод нийлүүлнэ.

6.1.5. Захиалагчийн объектод нийлүүлсэн тоног төхөөрөмжийг холбогдох заавар, стандартын дагуу суурилуулна.

6.1.6. Гэрээний хугацаанд суурилуулсан тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана. Үүнд тухайн тоног төхөөрөмжийн урсгал зардал, засвар үйлчилгээ багтана.

6.1.7. Гэрээний баталгаат хугацаанд захиалагчийн объектод нийлүүлсэн тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд тоног төхөөрөмжийг нэн даруй засварлах эсвэл солино.

6.1.8. Захиалагчийн объект дахь тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг шалган хүлээх авах акт болон “баталгааны хуудас”-г үйлдэн хүлээж авна.

6.1.9. Эрчим хүчний хэмнэлтийг Ажил гүйцэтгэгч баталгаажуулна. Хэрэв Захиалагч санал гаргасан бол эрчим хүчний хэмнэлтийг энэ гэрээнд заасан аудитын байгууллагаар баталгаажуулна.

6.2. Захиалагч бичгээр хүлээн зөвшөөрсөн тохиолдолд биечлэн гүйцэтгэхээс бусад Ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно.

6.3. Энэхүү гэрээний туслан гүйцэтгэгч нь _____ -н [талууд харилцан тохиролцсоноор Захиалагчийн эсвэл Ажил гүйцэтгэгчийн] өмнө хариуцлага хүлээнэ.

6.4. Гэрээний хугацаанд эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу гүйцэтгэсэн Ажлын тооцоолол, үр дүнг хэмжүүрийн нэгжээр нэгтгэн Захиалагчид мэдээлнэ.

6.5. Гэрээг цуцлах, талуудын хариуцлага ногдуулах бол урьдчилан мэдэгдэл хүргүүлсэн байна.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Гүйцэтгэлийн хуудсанд заасан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу гүйцэтгэсэн Ажлыг ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээн авна.

7.2. Гэрээнд заасны дагуу Ажлыг хүлээн авснаар төлбөр төлөх хуваарийн дагуу төлбөрийг төлнө.

7.3. Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээний дагуу Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай орчин нөхцөлөөр хангаж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

7.4. Гүйцэтгэх хуудсанд заасан эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээнд хамаарах Ажлыг _____ [талуудын гэрээгээр тавигдах шаардлагыг тохиролцох боломжтой] шаардлагын дагуу гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавина.

7.5. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу гүйцэтгэх Ажлын хэмжилт, үр дүнг хэмжүүрийн нэгжээр нэгтгэн ажил гүйцэтгэгчээс гаргуулан авна.

7.6. Гэрээг цуцлах, талуудын хариуцлага ногдуулах бол урьдчилан мэдэгдэл хүргүүлсэн байна.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН ХАМТРАН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Талууд эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан заавар, зөвлөмж өгч болно.

8.2. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд бүх талаар хамтран ажиллах, харилцан туслалцана.

8.3. Талууд хамтын үйл ажиллагааны явцад шаардлагатай холбогдох мэдээлэл, баримт бичгийг цаг тухайд нь шуурхай гаргаж өгнө.

8.4. Талууд энэхүү гэрээний хугацаанд нийтээр дагаж мөрдөж байгаа хүчин төгөлдөр Эрчим хүчний тарифын үнийг дагаж мөрдөх буюу тарифын үнийн өөрчлөлтийг тухай бүр нөгөө талдаа мэдээлнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТООЦООЛОЛ

9.1. Ажил гүйцэтгэгч нь эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хугацаа бүрт _____ кВт.цаг [энерги хэмжээ] -ийн эрчим хүчний хэмнэлт гаргаж, эрчим хүчний хэрэглээний зардлыг бууруулна.

9.2. Урьдчилсан эрчим хүчний хэрэглээнээс тухайн тооцооллын үеийн эрчим хүчний хэрэглээг хасах зарчмаар эрчим хүчний хэмнэлтийг тооцоолно.

9.3. Гэрээнд заасан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуух Ажлыг гүйцэтгэхээс өмнө Ажил гүйцэтгэгч нь аудитын тайланд үндэслэн урьдчилан эрчим хүчний хэрэглээг тооцоолно. Захиалагчийн объектын урьдчилсан эрчим хүчний хэрэглээний тооцоолол нь _____ кВт.цаг [энерги] байна;

9.4. Эрчим хүчний хэрэглээний тооцооллыг нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээний зарцуулалтыг тодорхойлох зарчмын дагуу тооцоолно.

9.5. Эрчим хүчний хэрэглээний тооцоолол хийхэд тухайн тооцоолол хийх хугацаанд эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан 1 кВт.цаг дахь тарифын үнэд үндэслэн мөнгөн дүнгээр илэрхийлнэ.[Талууд тарифын уналт болон өсөлтөөс үүдэх эрсдлийг гэрээгээр нарийвчлан тохиролцож болно]

АРАВДУГААР ЗҮЙЛ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

10.1. Гэрээнд заасан эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хугацаанд гэрээнд заасны дагуу эрчим хүчний хэмнэлтийг нэг удаа баталгаажуулж, ажил хүлээлцэх акт үйлдэнэ.

10.2. Дор дурдсан тохиолдолд эрчим хүчний хэмнэлт гаргасан гэж тооцно.Үүнд:

10.2.1. Гэрээнд заасан урьдчилсан эрчим хүчний хэрэглээнээс эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хугацаанд гарсан эрчим хүчний хэрэглээг хасахад гарсан дүн нь эрчим хүчний хэмнэлтийн дүнтэй тэнцүү болон түүнээс багагүй байх;

[хэрэв эрчим хүчний хэмнэлтийг ажил гүйцэтгэгч давуулан биелүүлсэн бол нэмэлт төлбөр олгохоор Талууд харилцан тохиролцож болно]

10.2.2. Эрчим хүчний хэмнэлтийг Ажил гүйцэтгэгч баталгаажуулна. Хэрэв Захиалагч санал гаргасан бол эрчим хүчний хэмнэлтийг эрх бүхий аудитын байгууллагаар баталгаажуулна.

10.2.3. Эрчим хүчний хэмнэлтийг _____ стандартын дагуу[талууд гэрээгээр нарийвчлан тохиролцох боломжтой] баталгаажуулна.

10.2.4. Эрчим хүчний хэмнэлтийг техникийн шаардлага хангасан зөөврийн болон суурин хэмнэлтийн багаж, тоног төхөөрөмж ашиглан баталгаажуулна.[Талууд эрчим хүчний хэмнэлтийг баталгаажуулахад ашиглах тоног төхөөрөмжийг нарийвчлан тохиролцож болно]

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

11.1. Гэрээнд заасан эрчим хүчний хэмнэлтийн _____ хувийг ажил гүйцэтгэгч, мөн _____ хувийг захиалагч гэрээнд заасан гэрээний баталгаат хугацаанд үр ашгийг хуваах зарчмын дагуу хуваарилна.

11.2. Гэрээнд заасан эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хугацаа нь нэг удаагийн төлбөр төлөх хугацаа байна.

11.3. Гэрээнд заасан эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хугацаанд гэрээнд заасны дагуу ажил хүлээлцэх акт үйлдэж, захиалагч Ажлыг хүлээн авч төлбөрийг хуваарийн дагуу төлнө.

11.4. Захиалагч нь гэрээнд заасан төлбөрийг ажил гүйцэтгэгчийн дараах дансанд төлнө.

Хүлээн авах банк: _____

Хүлээн авах дансны дугаар: _____

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

12.1. Ажил гүйцэтгэгч нь Ажлыг гэрээнд заасан хугацаа болон шаардлагын дагуу зохих ёсоор гүйцэтгээгүй нь давагдашгүй хүчин зүйлс болон захиалагчийн буруутай үйлдлээс болоогүй бол Ажил гүйцэтгэгч нь дараах анз төлөх үүрэгтэй.

12.1.1. Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _____ хувиар [0.5 хувиас хэтрэхгүй] тооцож, алданги оногдуулна.

12.1.2. Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _____ хувийн нөхөн төлбөр төлнө.

12.1.3. Гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол _____ [мөнгөн дүн] төгрөгийн нөхөн төлбөр төлнө.

12.1.4. Ажил гүйцэтгэгч нь 10.1-д зааснаас бусад үүргээ зөрчсөн тохиолдолд захиалагч нь тухайн зөрчлөөс үүдэлтэй хохирлыг дараах байдлаар шаардах эрхтэй.

12.1.5. Эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийг хуваарилах хугацааг _____ хойшлуулах;

12.1.6. Эрчим хүчний хэмнэлтийн үр ашгаас Захиалагчид хуваарилах хувийг _____ нэмэгдүүлэх;

12.1.7. Үүссэн бодит хохирлыг шууд шаардах;

12.1.8. Гэрээнд дагуу гэрээг цуцалж, учирсан хохирлоо шаардах;

12.2. Захиалагч нь гэрээнд заасан төлбөрийг заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Захиалагч нь дараах анз төлөх үүрэгтэй.

12.2.1. Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _____ хувиар [0.5 хувиас хэтрэхгүй] тооцож, алданги оногдуулна.

12.2.2. Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _____ хувийн нөхөн төлбөр төлнө.

12.2.3. Гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол _____ [мөнгөн дүн] төгрөгийн нөхөн төлбөр төлнө.

12.2.4. Захиалагч нь гэрээнд зааснаас бусад үүргээ зөрчсөн тохиолдолд ажил гүйцэтгэгч нь тухайн зөрчлөөс үүдэлтэй хохирлыг дараах байдлаар шаардах эрхтэй.

12.2.5. Эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийг хүртэх хугацааг _____ хойшлуулах;

12.2.6. Эрчим хүчний хэмнэлтийн үр ашгаас Ажил гүйцэтгэгчид хуваарилах хувийг _____ нэмэгдүүлэх;

12.2.7. Үүссэн бодит хохирлыг шууд шаардах;

11.2.8. Гэрээнд заасны дагуу гэрээг цуцалж, учирсан хохирлоо шаардах;

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

13.1. Гэрээний хугацаа нь _____ [гэрээ байгуулахаас гэрээ дуусгавар болох хүртэлх талуудын харилцан тохирсон сар, жил] байна.

13.1.1. Ажил гүйцэтгэж эхлэх хугацаа: _____

13.1.2. Ажил гүйцэтгэж дуусах хугацаа: _____

13.2. Эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох хугацаа: _____ [Талууд эрчим хүчний хэмнэлтийг тооцох хугацааг харилцан тохиролцоно]

13.3. Гэрээний баталгаат хугацаа: _____ [Ажлыг гүйцэтгэж дууссан хугацаанаас эхлэн гэрээ хугацаа дуусгавар болтол эрчим хүчний хэмнэлтийг баталгаажуулах хугацаа]

13.4. Энэхүү гэрээ нь “гэрээ хүчин төгөлдөр болох өдөр”-өөр хүчин төгөлдөр болж, энэхүү Гэрээнд заасан журмын дагуу цуцлагдахаас бусад тохиолдолд, гэрээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөнө.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

14.1. Гэрээний талууд хэдийд ч гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.

14.2. Гэрээнээс татгалзах, цуцлах, хохирол шаардах харилцааг Иргэний хуулийн холбогдох заалтыг удирдлага болгон шийдвэрлэнэ.

АРВАНТАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

15.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. *[Талууд хүчин төгөлдөр болох хугацааг тохиролцож болно]*

15.2. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд гэрээний 17.1-д заасан Захиалагч, Ажил гүйцэтгэгчийн албан ёсны хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.

АРВАНЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

16.1. Энэхүү гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

АРВАНДОЛДУГААР ЗҮЙЛ. БАТАЛГАА

17.1. Тал тус бүр нөгөө Талдаа дараах мэдэгдэл, баталгааг гаргаж байна:

17.1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдаж, хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа Монгол Улсын хуулийн этгээд болно.

17.1.2. Талууд энэхүү Гэрээг байгуулах болон энэхүү Гэрээнд заасан үүргээ биелүүлэх, ажил гүйлгээ эрхлэх өөрийн үйл ажиллагааг одоо явуулж байгаа болон ирээдүйд төлөвлөж байгаагаар эрхлэх бүрэн эрхтэй.

17.1.3. Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх, түүнчлэн энэхүү Гэрээнд заасан ажил гүйлгээг эрхлэхэд шаардлагатай зөвшөөрлийг компанийн удирдлагын эрх мэдлийн хүрээнд авсан болно.

17.1.4. Гэрээний нөхцлийг тогтоох, хүргүүлэх, хэрэгжүүлэх нь Талуудын хувьд: (i) холбогдох хууль тогтоомж, түүнийг даган гарсан аливаа дүрэм, журмыг зөрчихөд хүрэхгүй; (ii) компанийн дүрэм буюу үүсгэн байгуулах гэрээтэй зөрчилдөхгүй; (iii) тэдний нэгдэн орсон гэрээ буюу уг гэрээний дагуу эд хөрөнгөтэй нь холбоотойгоор хүлээлгэсэн үүрэгтэй нь зөрчилдөхгүй, зөрчих үр дагавар үүсгэхгүй; (iv) талуудын болон тэдний эд хөрөнгөтэй холбоотойгоор гарсан арбитр, шүүх болон захиргааны тогтоол, шийдвэрийг зөрчихгүй ба зөрчилдөхгүй.

АРВАННАЙМДУГААР ЗҮЙЛ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

18.1. Энэхүү гэрээний дагуу аль нэг тал нь хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлэхэд нь саад учруулах ямар нэгэн нөхцөл бүрэлдэх, тухайлбал, гал усны аюул, дайн, зэвсэгт бослого гарах, хориглолт бүслэлт хийх, эрх бүхий байгууллагаас экспорт, импортыг хориглосон шийдвэр гаргах, гоц халдварт өвчин, тахал гарах, газар хөдлөх, үер буух зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах бусад хүчин зүйл бий болбол гэрээгээр авсан үүргийг биелүүлэх хугацаа эдгээр хүчин зүйл дуусах буюу зогсох хүртэл хугацаагаар хойшилно.

18.2. Хэрэв энэ хүчин зүйл нь 6 сараас дээш хугацаагаар үргэлжилбэл аль ч тал гэрээгээр хүлээсэн үүргээсээ татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд нөгөө талаасаа хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхгүй болно.

18.3. Дээрх хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал нь учирсан хүчин зүйлийн эхлэлт төгсөлтийг нөгөө талдаа тухай бүр мэдэгдэх үүрэгтэй. Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны эрх бүхий байгууллага гэрчилнэ.

АРВАНЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

19.1. Энэхүү Гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд нэн тэргүүнд эвийн журмаар зөвшилцөн шийдвэрлэнэ.

19.2. Хэрэв талууд зөвшилцөлд хүрэхгүй бол талуудын хооронд үүсэн маргааныг агуулгаас хамаарч дараах харьяаллын дагуу тус тус шийдвэрлүүлнэ. Үүнд:

19.2.1. Эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан гарсан маргаан буюу эрчим хүч хэмнэлтийн ажил, үйлчилгээний чанартай холбоотой маргааныг Эрчим хүчний зохицуулах хороогоор;

19.2.1. Энэхүү гэрээний хүчин төгөлдөр байдал, төлбөр тооцоо зэргээр гэрээний зохицуулалттай холбоотой маргааныг Монгол Улсын шүүх эсхүл арбитраар шийдвэрлүүлнэ..

ХОРЬДУГААР ЗҮЙЛ МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ

20.1. Гэрээний талууд хоорондоо харилцаж, бие биедээ мэдээлэл, баримт бичиг, мэдэгдэл, тайлан өгөх, авах, дамжуулахдаа дор дурдсан итгэмжлэгдсэн этгээдэд болон хаягаар хүргүүлнэ:

- **ЗАХИАЛАГЧ:**

Итгэмжлэгдсэн этгээдийн нэр

Утасны дугаар:

Шуудангийн эсхүл албан ёсны хаяг:

- **АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:**
Итгэмжлэгдсэн этгээдийн нэр
Утасны дугаар:
Шуудангийн эсхүл албан ёсны хаяг:

20.2. Дээр дурдсан этгээдэд мэдэгдсэн, хүргүүлсэн эсхүл хүргүүлэхээр дээрх хаягаар илгээсэн бол тухайн мэдээлэл, баримт бичиг, мэдэгдэл, тайлан баримт бичиг хаягласан этгээдэд очсон, мэдэгдсэн, хүргүүлсэн гэж үзнэ. Мэдэгдэл захидлаар хүргүүлэхдээ баталгаат шуудан ашиглана.

ХОРИННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НЭМЭЛТ БАРИМТ БИЧИГ

21.1. Дараах гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.

Хавсралт 1- Ажлын төлөвлөгөө

Хавсралт 2- Ажлын төсөв

Хавсралт 3- Захиалагчийн объектын жагсаалт

Хавсралт 4- Гүйцэтгэх хуудас

Хавсралт 5- Төлбөр төлөх хуваарь

Хавсралт 6- Суурилуулах тоног төхөөрөмжийн жагсаалт

Хавсралт 7- Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

ХОРИНХОЁРДУГААР ЗҮЙЛ БУСАД ЗҮЙЛ

22.1. Гэрээг байгуулах, хүчин төгөлдөр болох, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, дуусгавар болгоход Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг баримтлана.

22.2. Гэрээний аль нэг заалт хүчингүй эсвэл хүчин төгөлдөр бус болсон бол энэхүү Гэрээний бусад заалт нь хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд хүчин төгөлдөр бус болсон тухайн заалт бусад нөхцөл байдалд хүчингүй хэвээр байна.

22.3. Гэрээ нь Талуудын бүх тохиролцоог агуулсан бөгөөд өмнө нь амаар эсвэл бичгээр байгуулсан бүх гэрээг нэгтгэсэн болно. Энэхүү Гэрээнд Талууд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

22.4. Гэрээнд талуудын бүрэн эрхт этгээд гарын үсэг зурснаар Гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд урьд өмнө нь явагдаж байсан хэлэлцээ, албан бичиг, санамж, бусад мэдээлэл хүчингүйд тооцогдоно.

ЭНД ЗААСНЫГ ГЭРЧЛЭН, Гэрээг ____ оны ____ дугаар/дүгээр сарын __ өдөр Монгол хэл дээр тус бүр _____ (____) эх хувиар үйлдсэн болно. Тал тус бүр _____ эх хувийг хадгалсан хуулийн хувьд хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧ:

“ _____ ” ХХК, ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ

_____ /гарын үсэг, тамга/

Нэр: _____

Албан тушаал: _____

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:

“ _____ ” ХХК, ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ

_____ /гарын үсэг, тамга/

Нэр: _____

Албан тушаал: _____

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

Нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/ эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 5.1.2-д зааснаар гэрээний талууд гүйцэтгэх хуудсанд заасан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу Ажлыг дараах төлөвлөгөөний дагуу гүйцэтгэхээр тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Ажил гүйцэтгэх үе шат

1-р үе шат	Ажил гүйцэтгэх үе шат	Онцлог тал	Ажил гүйцэтгэх хугацаа
	(a) Тухайн үе шатанд хамаарах Ажил		
1			
2			
3			
4			
5			
6			
2-р үе шат	(b) Ажил гүйцэтгэх үе шат	(c) Онцлог тал	(d) Ажил гүйцэтгэх хугацаа
	(e) Тухайн үе шатанд хамаарах Ажил		
1			
2			
3			
4			
5			

2. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт

Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг:

Хаяг:

Утас:

Утас:

Гарын

үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Гарын

үсэг: _____

(Тамга, тэмдэг)

АЖЛЫН ТӨСӨВ

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх)
түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил
гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/
эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 3.2-д зааснаар гэрээний талууд гүйцэтгэх Ажлын үнийн
дүнгийн задаргаа болон гэрээнд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг дараах байдлаар
тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Ажил гүйцэтгэгч нь гэрээний үнийн дүн _____ төгрөг [мөнгөн дүн] -н _____ хувь
буюу _____ төгрөгийн хөрөнгө оруулалт оруулж, энэхүү гэрээний эрчим хүчний
хэмнэлтийн арга хэмжээг Захиалагчийн объектод гүйцэтгэнэ.
2. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнд хөрөнгө оруулалт нь дараах үнийн дүнгийн
задаргаатай байна:

I. Ажил гүйцэтгэл, төлөвлөгөө,
инженерчлэл:

II. Тоног төхөөрөмжийн
нийлүүлэлт, суурилуулалт,
засвар үйлчилгээ :

_____ төгрөг _____ %

_____ төгрөг _____ %

3. Ажлын үнийн дүнгийн задаргаа

№	Захиалагчийн объектод хийж гүйцэтгэх Ажил /хавсралт 4 гүйцэтгэх хуудсанд тусгаснаар/	Үнийнралт
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		
	(f) Нийт үнийн дүн	(g) _____ төгрөг

4. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт
Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ЗАХИАЛАГЧИЙН ОБЪЕКТЫН ЖАГСААЛТ

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/ эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 4.1-д зааснаар дараах объектуудад эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуух Ажил гүйцэтгэхээр тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Ажил гүйцэтгэгч нь эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуух Ажлыг Захиалагчийн дараах объектуудад гүйцэтгэнэ.

Үл хөдлөх эд хөрөнгө:	
Үл хөдлөх эд хөрөнгө оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяалал:	

Объектуудын жагсаалт	
№	(h) Барилга байгууламж дахь тоног төхөөрөмж
1	
2	
3	
4	
5	
6	
7	
8	
9	
10	

2. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт

Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ГҮЙЦЭТГЭХ ХУУДАС

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

Нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/ эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 6.1-д зааснаар гэрээний талууд эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу дараах Ажлыг гүйцэтгэхээр тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнд дараах Ажил багтана.

№	Захиалагчийн объектод хийж гүйцэтгэх Ажил	Ажил гүйцэтгэж эхлэх хугацаа	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			

2. Ажлыг хүлээж авах

Дээрх эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу гүйцэтгэсэн Ажлыг эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээнд зааснаар Ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээж авна.

3. Ажил гүйцэтгэх хугацаа

Дээрх эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу Ажил гүйцэтгэх нийт хугацаа нь эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 11 дүгээр зүйлд зааснаар дараах хугацаа байна:

Ажил гүйцэтгэж эхлэх хугацаа: _____

Ажил гүйцэтгэж дуусгах хугацаа: _____

Гэрээний талууд эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний дагуу хийж гүйцэтгэх дээрх Ажил нэг бүрийн хугацааг харилцан тохиролцож тогтооно.

4. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт

Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын
үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ХАВСРАЛТ 5

ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/ эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 9.3-д зааснаар Захиалагч дараах хуваарийн дагуу гэрээний 9.1 дэх үр ашгийг хуваах зарчмийн дагуу гэрээний үнийг төлөхөөр тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Захиалагч гэрээний үнийг дараах хуваарийн дагуу хугацаанд нь төлнө:

Төлбөр төлөх хуваарь				
№	(i) Ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэх Ажил	Захиалагч ажлыг хүлээн авсан эсэх	Гэрээний үнэ төлөх хугацаа	Төлбөрийн мөнгөн дүн
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

3. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт

Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг:

Хаяг:

Утас:

Утас:

Гарын

үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Гарын

үсэг: _____

(Тамга, тэмдэг)

СУУРИЛУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/ эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 2.3-д зааснаар Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан шаардлага хангасан дараах тоног төхөөрөмжийг Захиалагчийн объектод суурилуулахаар тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Ажил гүйцэтгэгч нь дараах тоног төхөөрөмжийг Захиалагчийн объектод суурилуулна:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үйлдвэрлэгч, үйлдвэрлэсэн газар	Загвар	Техникийн үзүүлэлт	Тайлбар
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					

2. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт

Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас:

Утас:

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэг талаас _____ /захиалагчийн нэр/ (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/

болон

нөгөө талаас _____ /гүйцэтгэгчийн нэр/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж _____ /төлөөлөх эрх бүхий этгээд/ эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээний 5.1.8-д зааснаар гэрээний талууд тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг шалган тэдгээрийн техникийн үзүүлэлтийг баталгаажуулан хүлээн авахаар тохиролцож _____ оны _____ сарын _____ өдөр энэхүү хавсралтыг батлав.

1. Тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийн техникийн үзүүлэлт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үйлдвэрлэгч үйлдвэрлэсэн газар	Загвар	Техникийн үзүүлэлт	Суурилуулсан он	Тайлбар
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						

2. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг гүйцэтгэхийн өмнөх тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэрэглээний тооцоолол

a. Өмнөх хүчний хэмнэлтийн арга

№	Тоног төхөөрөмж	Эрчим хүчний хэрэглээ		
		(j) ____ он	(k) ____ он	____ он
		(l) 100%-н хүчин чадлыг тухайн жилд харьцуулсан харьцаа		
1				
2				
3				
4				
5				

b. Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг гүйцэтгэсний дараах эрчим хүчний хэрэглээг урьдчилан тооцоолсон байдал

№	Тоног төхөөрөмж	Эрчим хүчний хэрэглээ		
		(m) ____ он	(n) ____ он	____ он
		(o) 100%-н хүчин чадлыг тухайн жилд харьцуулсан харьцаа		
1				

2				
3				
4				
5				

3. Гэрээний талуудын хаяг, баталгаажуулалт

Захиалагч:

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)